



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 11589

Улаанбаатар хот

Захиалагчийн хяналт тавих тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 1 дүгээр хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

2. Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 2 дугаар хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Замын хөгжлийн газар (Б.Одбаяр)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хавсралтуудад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн "Захиалагчийн хяналт тавих тухай" А/109 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан жагсаалтын "8" дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

1725022703

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
04 сарын 05-ны өдрийн
19569 дүгээр захирамжийн
1 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо/	2022	2025	6,128.1	1,000.0
2	Сургуулийн барилга, 640 суудал (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 18 дугаар хороо)	2024	2026	9,400.0	1,000.0
Дүн				15,528.1	2,000.0

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
 04 дугаар сарын 02.2025 ны өдрийн
 21:56:09.991 UTC захирамжийн
 2 дугаар хавсралт

**НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ
 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

(сая төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Энхтайваны өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (25 дугаар эмийн сангийн уулзвараас Зүүн 4 замын уулзвар)	2024	2025	18,200.0	10,000.0
2	Найрамдлын авто замын засвар, шинэчлэлт. (Тахилтын уулзвараас Найрамдал зуслан)	2024	2026	20,058.9	3,000.0
				38,258.9	13,000.0

Digitized by srujanika@gmail.com


$$\frac{\partial \bar{m}}{\partial m} = \frac{\partial \bar{m}}{\partial \bar{m}} \cdot \frac{\partial \bar{m}}{\partial m}$$

બાળ

ପ୍ରକାଶିତ ଦିନ ୧୯୮୫



ପାଇଁରେ
କାହାରେ ଏବଂ କାହାରେ କାହାରେ



୦ ୦ ପ୍ରକାଶକ

ପ୍ରକାଶକ ମନ୍ତ୍ରୀ ମନ୍ତ୍ରୀ
ପ୍ରକାଶକ ମନ୍ତ୍ରୀ ମନ୍ତ୍ରୀ

ପ୍ରକାଶକ / ଶେ ମିଛାନୀର / ପାଠୀକାରୀ / ମାତ୍ର 《L》 ଏହି ଲାଇସେନ୍ସ / ମାତ୍ର କିମ୍ବାକୁ ଏହି ପାଠୀକାରୀ ॥
ମାତ୍ର ୩୦-୯ ଟଙ୍କା ମାତ୍ର 《ପାଠୀକାରୀ ମାତ୍ର ଲେଖକ / ଅଧିକାରୀ ମାତ୍ର》 ୨/୨୦୧ ଏହି ଲାଇସେନ୍ସ ମାତ୍ର ୨ ଟଙ୍କା
୦ ୦ ମାତ୍ର ଲାଇସେନ୍ସ / କିମ୍ବାକୁ ଏହି ପାଠୀକାରୀ ମାତ୍ର ୧୦୨୧ ମାତ୍ର ୦୭ ଟଙ୍କା

ପାଠୀକାରୀ ମାତ୍ର ୦୦ ଟଙ୍କାଟାରୀ ଏହି ପାଠୀକାରୀ ॥

ପାଠୀକାରୀ ମାତ୍ର ମାତ୍ର ଏହି
୦ ୦ ଲାଇସେନ୍ସ / ଏହି ଏହି